

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/02/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум

2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЕП	Монгол Улсын Ерөнхий Прокурор



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.10 № 01/60
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ГАНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны тогтмол зардал өмнөх оноос 50 хувиар өссөн байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд: Хуучин байр нь Прокурорын газрын баланст бүртгэлтэй учраас оны эхэнд тогтмол зардлын төсөв нь тус байгууллага дээр батлагдсан байсан. Төсвийн жилийн дундуур шинэ байранд нүүж орсноос хойш тогтмол зардал давхар төлөгдөж байгаатай холбоотой байна

Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Прокурорын газар нь тайлант оны 9 дүгээр сард улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга байгууламжийг ашиглаж эхэлсэн боловч төсөвт өртөг нь тодорхойгүй, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас барилга байгууламжийг ашиглагч байгууллагад шилжүүлсэн шийдвэр гараагүй тул тайлан баланст тусгаагүй байна

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 43 арга хэмжээний хүрээнд 100 хувийн биелэлттэй ажилласан гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /А.ЭРДЭНЭБААТАР/



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,347,280.00	53,912,805.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,700,000.00	14,200,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,700,000.00	14,200,000.00
3121	Төгрөг	1,700,000.00	14,200,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	1,700,000.00	14,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	30,647,280.00	39,712,805.00
354	Хангамжийн материал	30,647,280.00	39,712,805.00
35420	Аж ахуйн материал	4,952,780.00	27,511,305.00
35450	Барилгын засварын материал	22,000,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	3,694,500.00	12,201,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	542,256,335.98	579,124,061.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	542,256,335.98	579,124,061.94
392	Биет хөрөнгө	456,981,335.98	493,849,061.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	306,069,720.00	306,069,720.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,446,076.56	-42,920,416.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,700,000.00	75,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-88,074,999.94	-35,558,333.27
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,527,482.79	147,088,223.19
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71,516,808.72	-35,506,956.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,666,415.38	105,350,275.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,944,396.97	-26,473,450.43
393	Биет бус хөрөнгө	85,275,000.00	85,275,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	85,275,000.00	85,275,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	574,603,615.98	633,036,866.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,700,000.00	14,200,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,700,000.00	14,200,000.00
414	Урьдчилж орсон орлого	1,700,000.00	14,200,000.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	1,700,000.00	14,200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	572,903,615.98	618,836,866.94
51	Засгийн газрын хувь оролцоо	572,903,615.98	618,836,866.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	277,731,556.90	277,731,556.90
51101	Өмч: - төрийн	277,731,556.90	277,731,556.90
512	Хуримтлагдсан үр дүн	234,530,706.34	280,463,957.30
51210	Өмнөх үеийн үр дүн	234,530,706.34	234,530,706.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	45,933,250.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,641,352.74	60,641,352.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	574,603,615.98	633,036,866.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	862,195,814.00	1,018,004,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,363,914.00	64,327,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	39,363,914.00	64,327,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,363,914.00	64,327,550.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,363,914.00	64,327,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	822,831,900.00	953,676,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	822,831,900.00	943,676,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	822,831,900.00	943,676,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	758,431,196.02	972,070,899.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	758,431,196.02	972,070,899.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	745,244,481.64	924,284,273.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499,060,813.62	628,333,548.00
210101	Үндсэн цалин	331,176,043.00	400,264,632.00
210102	Нэмэгдэл	145,738,873.38	174,175,636.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,145,897.24	25,150,089.00
210104	Урамшуулал	00.00	28,743,191.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,600,657.00	76,752,371.00
210201	Тэтгэврийн даатгал	44,154,136.06	52,419,586.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,861,630.37	6,083,195.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,889,303.64	4,866,556.36
210204	Ажилгүйдлийн даатгал	972,326.19	1,216,639.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,723,260.74	12,166,393.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,272,700.00	63,846,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,930,480.00	3,891,668.00
210302	Түлш, халаалт	23,327,723.00	22,901,038.00
210303	Цэвэр, бохир ус	1,514,497.00	3,782,041.00
210304	Байрны түрээс	10,500,000.00	33,271,953.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,099,200.00	28,394,075.00
210401	Бичиг хэрэг	12,075,000.00	9,924,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,100,000.00	10,865,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,522,900.00	3,327,500.00
210404	Ном, хэвлэл	9,801,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	951,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	3,326,475.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,790,900.00	35,544,000.00
210604	Урсгал засвар	19,790,900.00	35,544,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,602,000.00	5,800,000.00
210702	Дотоод албан томилолт	2,602,000.00	5,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,977,200.00	16,456,255.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,650,000.00	15,925,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	730,800.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,600.00	170,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	381,800.00	316,655.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,841,011.02	69,157,324.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	2,697,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,291,000.00	9,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,750,011.02	57,459,824.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,186,714.38	47,786,626.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,260,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,186,714.38	45,526,626.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,186,714.38	45,526,626.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	103,764,617.98	45,933,250.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	103,764,617.98	45,933,250.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	824,331,900.00	966,176,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,500,000.00	12,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,500,000.00	12,500,000.00
120009	Бусад орлого	1,500,000.00	12,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	822,831,900.00	953,676,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	822,831,900.00	943,676,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	822,831,900.00	943,676,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	748,830,900.00	923,676,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	748,830,900.00	923,676,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	735,144,185.62	875,889,974.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	499,060,813.62	628,333,548.00
210101	Үндсэн цалин	331,176,043.00	400,264,632.00
210102	Нэмэгдэл	145,738,873.38	174,175,636.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,145,897.24	25,150,089.00
210104	Урамшуулал	00.00	28,743,191.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,201,372.00	76,752,371.00
210201	Тэтгэврийн даатгал	43,754,850.52	52,419,586.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,861,630.37	6,083,195.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,889,304.18	4,866,556.36
210204	Ажилгүйдлийн даатгал	972,326.19	1,216,639.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,723,260.74	12,166,393.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,272,700.00	63,846,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,930,480.00	3,891,668.00
210302	Түлш, халаалт	23,327,723.00	22,901,038.00

210303	Цэвэр, бохир ус	1,514,497.00	3,782,041.00
210304	Байрны түрээс	10,500,000.00	33,271,953.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,099,200.00	38,027,600.00
210401	Бичиг хэрэг	12,075,000.00	9,924,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,100,000.00	10,865,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,522,900.00	3,327,500.00
210404	Ном, хэвлэл	9,801,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	951,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	12,960,000.00
2105	Нормативт зардал	00.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,289,900.00	13,544,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	499,000.00	00.00
210604	Урсгал засвар	41,790,900.00	13,544,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,602,000.00	5,800,000.00
210702	Дотоод албан томилолт	2,602,000.00	5,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,527,200.00	32,938,255.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,200,000.00	32,407,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	730,800.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,600.00	170,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	381,800.00	316,655.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,091,000.00	15,147,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,800,000.00	6,147,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,291,000.00	9,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,686,714.38	47,786,626.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	500,000.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	500,000.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,260,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,186,714.38	45,526,626.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,186,714.38	45,526,626.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	75,501,000.00	42,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	74,501,000.00	30,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	74,501,000.00	30,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	74,501,000.00	30,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	74,501,000.00	30,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-74,501,000.00	-30,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,000,000.00	12,500,000.00

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	700,000.00	1,700,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,700,000.00	14,200,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,431,556.90	60,641,352.74	130,766,088.36	439,838,998.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	248,431,556.90	60,641,352.74	130,766,088.36	439,838,998.00
C07	Тайлант үеийн үр дүн	29,300,000.00	00.00	103,764,617.98	133,064,617.98
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,731,556.90	60,641,352.74	234,530,706.34	572,903,615.98
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,731,556.90	60,641,352.74	234,530,706.34	572,903,615.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	277,731,556.90	60,641,352.74	234,530,706.34	572,903,615.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	45,933,250.96	45,933,250.96
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,731,556.90	60,641,352.74	280,463,957.30	618,836,866.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	943,676,600.0	898,149,974.0	45,526,626.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	943,676,600.0	898,149,974.0	45,526,626.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	941,416,600.0	895,889,974.0	45,526,626.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	667,153,200.0	628,333,548.0	38,819,652.0
210101	Үндсэн цалин	382,474,800.0	400,264,632.0	-17,789,832.0
210102	Нэмэгдэл	233,788,800.0	174,175,636.0	59,613,164.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,467,600.0	25,150,089.0	10,317,511.0

210104	Урамшуулал	15,422,000.0	28,743,191.0	-13,321,191.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,394,200.0	76,752,371.0	6,641,829.0
210201	Тэтгэврийн даатгал	58,648,800.0	52,419,586.5	6,229,213.5
210202	Тэтгэмжийн даатгал	6,186,300.0	6,083,195.5	103,104.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,949,100.0	4,866,556.4	82,543.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,237,300.0	1,216,639.1	20,660.9
210205	Эрүүл мэндийн даатгал	12,372,700.0	12,166,393.5	206,306.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,846,700.0	63,846,700.0	00.0
210301	Гэрэл, цахилгаан	4,969,300.0	3,891,668.0	1,077,632.0
210302	Түлш, халаалт	18,188,800.0	22,901,038.0	-4,712,238.0
210303	Цэвэр, бохир ус	5,688,600.0	3,782,041.0	1,906,559.0
210304	Байрны түрээс	35,000,000.0	33,271,953.0	1,728,047.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,027,600.0	38,027,600.0	00.0
210401	Бичиг хэрэг	9,924,000.0	9,924,000.0	00.0
210402	Тээвэр, шатахуун	10,865,100.0	10,865,100.0	00.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,327,500.0	3,327,500.0	00.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	951,000.0	951,000.0	00.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,960,000.0	12,960,000.0	00.0
2105	Нормативт зардал	1,500,000.0	1,500,000.0	00.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,500,000.0	00.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,544,000.0	43,544,000.0	00.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.0	10,000,000.0	00.0
210602	Тавилга	20,000,000.0	20,000,000.0	00.0
210604	Урсгал засвар	13,544,000.0	13,544,000.0	00.0
2107	Томилолт, зочны зардал	5,800,000.0	5,800,000.0	00.0
210702	Дотоод албан томилолт	5,800,000.0	5,800,000.0	00.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,003,400.0	22,938,255.0	65,145.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,407,000.0	22,407,000.0	00.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,600.0	170,600.0	00.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	44,000.0	00.0
210807	Газрын төлбөр	381,800.0	316,655.0	65,145.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,147,500.0	15,147,500.0	00.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,147,500.0	6,147,500.0	00.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,000,000.0	9,000,000.0	00.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,260,000.0	2,260,000.0	00.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,260,000.0	2,260,000.0	00.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260,000.0	2,260,000.0	00.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	943,676,600.0	898,149,974.0	45,526,626.0

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	943,676,600.0	943,676,600.0	00.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	943,676,600.0	943,676,600.0	00.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	1,700,000.00	-1,700,000.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	14,200,000.00	-14,200,000.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Прокурорын байгууллага нь Төрийн нэрийн өмнөөс Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий үйл ажиллагааг явуулдаг бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага юм.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан прокурорын газрын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны зарчим, баталгаа, прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, эрх хэмжээ, бие даасан байдлыг хангах эрх зүйн үндсийг тогтооход тус байгууллагын эрхэм зорилго оршино. Эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагааг их өгөгдөлд суурилсан бодлогын инновацаар удирдах,
2. Хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх,
3. Прокурорын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй, хялбар болгох,
4. Прокурор, ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, нийгмийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хувь хүнийг төлөвшүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Хөвсгөл аймгийн Прокурорын газар нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Прокурорын тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: МУЕП-ын газарт Дотоод хяналт, шалгалтын хэлтэс ажилладаг бөгөөд харьяа газруудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулдаг байна. Хөвсгөл аймгийн прокурорын газарт дотоод хяналтын нэгж, ажилтан ажиллахгүй байна. Тайлант онд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байгаа нь байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мөн Хөвсгөл аймгийн Прокурорын газрын санхүү бүртгэлийн зарим үйл ажиллагаанд дарга, нягтлан бодогчид 1,2 дугаар шатны хяналтыг хангалттай хэрэгжүүлж чадахгүй байна гэж үнэллээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулахдаа анхан

шатны баримтад буй мэдээлэлд хяналт тавиагүй, баримтын бүрдэл дутуу, хоосон баримт бүрдүүлсэн ажил гүйлгээ гарсан байгааг асуудлын бүртгэлд тусган баталгаажууллаа.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй, үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Монгол улсын Ерөнхий прокурорын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг удирдлага болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,433.3 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	30,647.3	39,712.8	9,065.5
Үндсэн хөрөнгө	542,256.3	579,124.1	36,867.8
Нийт хөрөнгө	574,603.6	633,036.9	58,433.3
Өр төлбөр	1,700.0	14,200.0	12,500.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	572,903.6	618,836.9	45,933.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	574,603.6	633,036.9	58,433.3

Дээрх хүснэгтээс харахад бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 9,065.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны 9 дүгээр сард шинэ байранд нүүж орохтой холбоотой монгол бичгийн хаяг, гэрлэн хаяг, алдрын булан, самбар хийлгэсэнтэй холбоотой байна.

Мөн үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 36,867.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд дээд газраас 22,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий ниссан патрол авто машин, 42,327.5 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж хүлээн авсан, төсвөөс 30,000.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой өсөлт байна. Тайлант онд барьцаа хөрөнгийн дансанд 14,200.0 мянган төгрөг төвлөрч, 3,400.0 төгрөгийн барьцааг чөлөөлсөнтэй холбоотой өр төлбөрийн данс 12,500.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 912,973.5 мянга, нийт зарлагыг 912,973.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 151,157.1 мянган төгрөгөөр бууруулж, 761,816.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг боловсруулахдаа тайлант онд шинэ байранд нүүж орохтой холбоотой гарах тохижилт үйлчилгээний зардал, тогтмол зардлыг тооцсон байна. Мөн Хөвсгөл нуурын тусгай хамгаалалттай газар шинээр сургалтын төв /бааз/ барих, байгууллагын албаны орон сууцны их засварын зураг төсвийн 12,000.0 мянган төгрөгийг тооцон төсвийн төсөлд тусгасан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 181,860.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 973,676.6 мянган төгрөгийг улсын төсвөөс олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 898,149.9 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 38,819.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлыг 6,641.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70703-Прокурорын хяналт	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	935,316.6	889,789.9	45,526.7	95.2%
2		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,260.0	2,260.0	0	100%
3		82315-Байцаан шийтгэх ажиллагаа	6,100.0	6,100.0	0	100%
Нийт дүн			943,676.6	898,149.9	45,526.7	95.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ЗДНХөрөнгөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч иргэдийн мэдлэг мэдээллийг сайжруулах зорилгоор 10.0 мянган ширхэг сурталчлан таниулах материал хэвлүүлж, тараасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн зарцуулалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын захирал, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 222 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 758,431.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 15,168.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрсэнгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
 - Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ
 - Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл
1. Нийт 51 мэдээлэл байршуулахаас 47 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.
 2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 946,237.8 мянган төгрөгийн 12 гүйлгээний мэдээллийг 100 хувь хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль: Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.
2. Төсвийн тухай хууль: Аудитын явцад нягтлан бодогчоос авсан асуулга, анхан шатны баримтын тулгалт хийсний үр дүнд зарим хөрөнгө, материалын хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоолоогүй, шаардлагагүйгээр их хэмжээгээр хөрөнгө материал бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/ 16 дугаар зүйлийн 16.5.5 /Төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.
3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль: Тээвэр шатахууны зардлаас 10 дугаар сард шилжүүлсэн 3,290.1 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 1,010.1 мянган төгрөгийн шатахууны зардал анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 2 асуудалд 2 зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн дансны үнэ бодит үнээсээ зөрүүтэй байгаа биет болон биет бус хөрөнгийг дахин үнэлэх, цаашид ашиглах боломжгүй бол данснаас хасах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх тухай зөвлөмжийн хүрээнд эрх бүхий байгууллагын шийдвэрээр 135,982.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж, цаашид ашиглагдах боломжтой хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	100%
Нийт дүн	1	0	1	0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30,507.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 30,507.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

1. Урсгал засварт зарцуулсан барилгын засвар, засал чимэглэлийн материал болох 22,000.0 мянган төгрөгийн материалыг зарлагадаагүй байна.
2. Тайлант онд 8,507.0 мянган төгрөгийн байгууллагын хаяг, самбар, алдрын булан зэрэг бусад хангамжийн материалыг бичиг хэргийн материалд орлого авсан байна.

Аудитаар нийт 1,010.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,010.0 төгрөгийн 2 зөрчилд зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тээвэр шатахууны зардлаас 10 дугаар сард шилжүүлсэн 3,290.1 төгрөгийн гүйлгээг анхан шатны баримттай тулган шалгахад 1,010.1 төгрөгийн шатахууны зардал анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ гэсэн заалтад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг санхүүжүүлж, 1,2 дугаар түвшний дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт: Аудитын явцад нягтлан бодогчоос авсан асуулга, анхан шатны баримтын тулгалт хийсний үр дүнд зарим хөрөнгө, материалын хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоолоогүй, шаардлагагүйгээр их хэмжээгээр хөрөнгө материал бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/ 16 дугаар зүйлийн 16.5.5 /Төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Төсвийг төлөвлөхдөө байгууллагын хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоолж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулж, шаардлагагүйгээр их хэмжээний хөрөнгө материал бэлтгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дээврийн засварт зарцуулсан урсгал засварын материалыг зарлагдаагүй байсан	1	22,000.0	-	-	1	22,000.0	1	22,000.0	-	-	-	-
Бараа материалын ангилал зөрүүлж орлогдсон.	1	8,507.0	-	-	1	8,507.0	1	8,507.0	-	-	-	-
Дүн	2	30,507.0			2	30,507.0	2	30,507.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан	1	1,010.0	-	-	-	-	1	1,010.0	-	-	-	-
Хөрөнгө материалын хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоолоогүй.	1	0	-	-	-	-	1	0	-	-	-	-
Дүн	2	1,010.0					2	1,010.0				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

11/10

11/10

11/10